

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2023/21/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2023 он

Цахим хуудас: www.open.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.04.04

№

323

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бор-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 735,674.2 мянган төгрөг, авлага 794,806.0 мянган төгрөг, бараа материал 183,238.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 9,784,885.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 11,598,103.4 мянган төгрөг байна.

Тайлант онд 4,931,408.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 2,298,550.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, аймгийн төсөвт 2,133,322.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Оны эцэст төсөвт байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 90,869.2 мянган төгрөгийг сумын ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 362,539.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 354,660.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 7,878.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бор-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 798,737.7 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг залруулсан.

2823304'

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэх шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,476,424.8	1,813,218.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	811,087.4	735,674.2
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,019,068.6	716,159.1
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	36,500.0	178,146.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	609,768.8	183,238.1
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		16,909,700.0	9,784,885.1
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	16,909,700.0	9,784,885.1
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		15,701,192.7	9,144,568.1
39300	Биет бус хөрөнгө	13	1,208,507.3	640,317.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		19,386,124.8	11,598,103.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		98,731.3	14,670.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	98,731.3	14,670.5
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	98,731.3	14,670.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	0.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		19,287,393.4	11,583,432.9
51	Засгийн газрын хувь оролцоо		19,287,393.4	11,583,432.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		4,421,220.2	1,375,949.9
51100	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		0.0	0.0
1				
51100	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0.0	1,375,949.9
2				
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн		923,764.5	2,503,059.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		13,942,408.7	7,704,423.8
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		19,386,124.8	11,598,103.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		10,483,319.0	6,528,163.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		459,834.8	4,123,654.4
110	Орлогын албан татвар		297,260.0	3,583,078.0
1100	Хувь хүний орлогын албан татвар		297,260.0	3,583,078.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		28,273.0	246,416.9
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		134,301.8	294,159.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,765,216.9	1,134,058.2
120	Нийтлэг татварын бус орлого		3,741,505.9	1,134,058.2
121	Хөрөнгийн орлого		0.0	0.0
122	Тусламжийн орлого		23,711.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0.0	0.0
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,258,267.3	1,270,450.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	7,911,375.9	5,942,626.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,911,375.9	5,940,839.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,503,036.6	3,747,731.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,752,044.7	968,112.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		488,717.6	117,416.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		518,813.4	656,258.9
2104	Хангамж, бараа материалын зардал		238,733.0	128,688.5
2105	Нормативт зардал		187,904.4	80,232.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		195,914.3	127,376.2
2107	Томилолт, зочны зардал		16,811.2	26,913.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		780,339.7	1,506,574.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,323,758.2	136,159.1
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		87,354.3	967.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		320,985.0	2,192,140.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	1,787.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,571,943.1	585,536.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		5,709.7	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,079,260.0	15,914,046.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,498,392.8	-15,328,509.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,794,710.4	0.0	17,794,710.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,794,710.4	0.0	17,794,710.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	-5,709.7	0.0	-5,709.7
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,498,392.8	0.0	1,498,392.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,287,393.4	0.0	19,287,393.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,287,393.4	0.0	19,287,393.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,612,004.2	0.0	7,612,004.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,899,397.7	0.0	26,899,397.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	12,545.0	0.0	12,545.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-15,328,509.8	0.0	-15,328,509.8
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,583,432.9	0.0	11,583,432.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,287,325.0	5,920,126.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	459,834.8	4,123,654.4
110	Орлогын албан татвар	297,260.0	3,583,078.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	297,260.0	3,583,078.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	28,273.0	246,416.9
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	134,301.8	294,159.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	50,661.4	67,840.9
1181	Газрын төлбөр	77,656.0	226,098.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,984.4	220.0
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,676,885.1	556,200.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,665,585.1	556,200.6
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	11,300.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,150,605.1	1,240,271.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,957,858.0	5,286,189.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,957,858.0	5,286,189.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,548,879.0	2,928,836.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,743,646.5	968,833.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	494,033.9	117,662.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	537,966.7	656,258.9
2104	Хангамж, бараа материалын зардал	269,639.4	121,375.4
2105	Нормативт зардал	215,287.3	64,505.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	180,876.7	139,789.3
2107	Томилолт, зочны зардал	16,811.2	26,963.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	791,408.9	770,687.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,208.4	62,760.6
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	87,354.3	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,624.8	2,357,353.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,329,467.0	633,936.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,163,885.1	709,349.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,163,885.1	709,349.4
2200	Дотоод эх үүсвэрээр	1,163,885.1	709,349.4
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,163,885.1	-709,349.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	0.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	165,581.8	-75,413.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	645,505.5	811,087.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	811,087.4	735,674.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,652,443.50	2,740,979.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,260,469.50	2,195,534.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,221,492.90	2,156,565.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	654,661.90	622,653.48
210101	Үндсэн цалин	263,638.70	324,707.23
210102	Нэмэгдэл	77,244.90	60,102.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,500.00	26,012.00
210104	Урамшуулал	24,141.10	27,781.88
210105	Гэрээт ажлын хөлс	245,137.20	184,049.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,068.60	74,834.41
210201	Тэтгэврийн даатгал	54,931.10	52,810.01
210202	Тэтгэмжийн даатгал	6,534.70	6,152.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,226.90	4,878.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,307.00	1,003.27
210205	Эрүүл мэндийн даатгал	13,068.90	9,990.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	667,492.60	645,810.51
210301	Гэрэл, цахилгаан	73,204.90	75,508.00
210302	Түлш, халаалт	462,641.60	439,153.27
210303	Цэвэр, бохир ус	127,626.00	127,129.18
210304	Байрны түрээс	4,020.10	4,020.07
2104	Хангамж, бараа материалын зардал	53,386.10	53,208.35
210401	Бичиг хэрэг	8,994.40	10,064.50
210402	Тээвэр, шатахуун	32,131.10	29,591.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,581.30	3,873.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,679.30	9,678.18
2105	Нормативт зардал	652.10	603.77
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	652.10	603.77
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,816.70	139,789.30
210604	Урсгал засвар	139,816.70	139,789.30
2107	Томилолт, зочны зардал	11,920.20	11,898.00
210702	Дотоод албан томилолт	11,920.20	11,898.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	568,705.20	566,909.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,172.30	565,880.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	36.70	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	511.90	237.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261.00	169.41
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89.50	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602.20	569.45
210807	Газрын төлбөр	31.60	31.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,789.50	40,857.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,200.00	38,271.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,589.50	2,586.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,976.60	38,968.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,000.00	31,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,000.00	31,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,976.60	7,968.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313.20	6,313.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,663.40	1,655.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	765,870.70	545,445.21
223001	Бусад хөрөнгө	765,870.70	545,445.21
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	626,103.30	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	626,103.30	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,652,443.50	2,845,183.57
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,785,770.40	2,605,282.21
320001	Орон нутгийн төсвөөс	2,388,169.50	2,207,681.31
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	397,600.90	397,600.90
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	866,673.10	239,901.36
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	430,493.40	139,601.36
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300.00	100,300.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	435,879.70	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	439,836.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	527,172.39

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	362,539.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,499.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,620.64
2104	Хангамж, бараа материалын зардал	1,370.00
210401	Бичиг хэрэг	770.00
210402	Тээвэр, шатахуун	280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221,570.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,570.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,878.97
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,878.97
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,878.97
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,039.59
2200	Дотоод эх үүсвэрээр	112,039.59
220001	Барилга байгууламж	112,039.59
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	362,539.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	362,539.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,613.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	343,926.10

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Бор-Өндөр сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 798,737.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- ЖДБДС: Хаалтын тайлан хийхдээ орлого үр тайланд үнэ төлбөргүй гарсан зардлыг 40,894.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн
- Их ирээдүй сургууль: Хаалтын тайлан хийхдээ 897.7 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр хүлээж авсан /204/ дансанд хасах тэмдгээр бүртгэж алдаатай нэгтгэсэн
- ЭЭС: Хаалтын тайлан хийхдээ 54.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлаар бүргэж тайлант оны үр дүнг алдаатай илэрхийлсэн
- Хот тохижилтын газар: Төсвийн байгууллагын ангилалд шилжсэнтэй холбоотой 678,244.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын эхний үлдэгдлийг шилжүүлж авах дансны бичилтийг алдаатай илэрхийлсэн.
- ОНХС: Он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний урьдчилж олгосон санхүүжилт 78,646.9 мянган төгрөгийг дансны ангиллын даруу бүртгэл хөтлөөгүй, авлагын дансанд илэрхийлсэн.

3.2 Бор-Өндөр сумын харьяа улсын болон орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын дүн, илэрсэн алдаа зөрчил.

Бор-Өндөр сумын засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 3, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 3, төрийн сан 1, орон нутгийн тусгай сан 4, улсын төсвийн байгууллага 7, нийт 18 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнээс 5 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган, 9 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж аудитад хамруулсан. Их ирээдүй сургууль, ЖДБДС, ЭЭС, Хот тохижилт үйлчилгээний газар ОНӨААН зэрэг 4 байгууллагын хаалтын балансыг Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд шалгасан болно.

Аудит хийж дүгнэлт гаргасан ЗДТГ, Хот тохижилтын газар, МСҮТ-ийн санхүүгийн тайланд Төрийн аудитын газар, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Бор-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 770,189.2 мянган төгрөгийн 8 алдаа, 106,212.8 мянган төгрөгийн 9 зөрчил, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар шилэн дансны тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,420,027.8 мянган төгрөгийн 6 зөрчил, нийт 2,296,429.8 мянган төгрөгийн 24 алдаа зөрчил илэрлээ.

Үүнээс 770,189.2 мянган төгрөгийн 8 алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 432,539.8 мянган төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгч, 2,133.6 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,091,567.2 мянган төгрөгийн 5 зөрчлийн арилгах албан шаардлага хүргүүлээ.

Алдаа зөрчлийг байгууллагаар нь авч үзвэл:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Засаг даргын тамгын газар:

- Өвс тэжээлийн агуулах саравч, худгийн үнийн урьдчилгаанд 91,000.0 мянган төгрөгийг шилжүүлж зардалд хаасан, 14,370.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогын дансны бичилтийг алдаатай хөтөлж үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй тусгасан, 30,620.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Цалингийн урьдчилгаанд 700.0 мянган төгрөг олгож, цалингаас суутгаагүй зардалд хаасан

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Цалингийн зардлыг зориулалт бус зарцуулж 4,485.6 мянган төгрөгийн газрын хянан баталгаажуулалтын гэрээний зардалд шилжүүлсэн.
- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 112,139.6 мянган төгрөгийн 8 гүйлгээ болон худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй зэрэг нийт 112,139.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба мэдээлсэн байдлын хэрэгжилт 82.7 хувь байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв

- Анхан шатны баримтын бүрдэлгүй /и баримтгүй/ ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 6,060.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан,
- Бараа материалын данснаас урсгал засварт тавьж олгосон материалыг зарлагадаагүй үлдэгдлээр илэрхийлсэн

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Хот тохижилтын газар:

- Тухайн байгууллагын нэр дээр эзэмших гэрчилгээтэй 12,545.0 мянган төгрөгийн газрыг санхүүгийн тайландаа үнэлж бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Түрээсийн орлогын 40 хувийг 249.7 мянган төгрөгөөр төсөвт дутуу төвлөрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 388,172.2 мянган төгрөгийн 27 гүйлгээ, зарлагын 260,772.3 мянган төгрөгийн 10 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийн тухайн хэсэгт үнэн зөв байршуулаагүй зэрэг нийт 648,944.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв

- Авлагын үлдэгдэл өмнөх оноос 67,236.0 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин нэмэгдсэн нь авлагыг барагдуулах талаар хийсэн ажил хангалтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Ерөнхий боловсролын сургууль:

- Сахилгын шийтгэлтэй 3 албан хаагчийн цалингаас суутгасан суутгалын 1,244.3 мянган төгрөгийг орон нутгийн хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлээгүй, мөн сахилгын шийтгэл оногдуулсан 1 ажилтанд сахилгын шийтгэл тооцсоноос хойш 512.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 16,467.9 мянган төгрөгийн 140 тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын 173,887.6 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 89,445.7 мянган төгрөгийн 9 гүйлгээ, тендерийн 155,589.9 мянган төгрөгийн 1 мэдээллийг тус тус байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв:

- Зураг төсвийн үнэ 3,300.0 мянган төгрөгийг зардалд хаасан.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Автомашины шатахуун зарцуулалтыг тогтоосон нормыг хэтрүүлэн зарцуулсан 1,183.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Хугацаа хэтэрсэн 988.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв

- Багаж техник хэрэгслийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 5,000.0 мянган төгрөгийг урсгал засварын төлбөр төлсөн.
- Шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш орлогын 3 гүйлгээ 34,846.5 мянган төгрөг, зарлагын 21 гүйлгээ 165,675.7 мянган төгрөг, нийт 200,522.2 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй.
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээ өмнөх оноос 22,042.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Соёлын төв:

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн тайланд 17,694.9 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

Цэгцүүлэн дом өрхийн эрүүл мэндийн төв:

- Мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 120,528.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 480,130.9 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дансны ангиллыг алдаатай бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	798,737.7			1	798,737.7	1	798,737.7				
ЗДТГ	3	135,990.0			3	135,990.0	3	135,990.0				
Хот тохижилтын газар	1	12,545.0	1	12,545.0			1	12,545.0				
Дүн	5	947,272.7	1	12,545.0	4	934,727.7	5	947,272.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	30,876.1	1	700.0	1	4,485.6	2	25,690.5				
Хот тохижилтын газар	3	67,395.6	1	249.7	-	-	2	67,145.9				
Дүн	7	98,271.7	2	949.7	1	4,485.6	4	92,836.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Хот тохижилтын газар	1	648,944.5					1	648,944.5				
ЗДТГ	1	112,139.0								1	112,139.0	
Дүн	2	761,083.5					1	648,944.5		1	112,139.0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн	2	761,083.5					1	648,944.5		1	112,139.0	

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	10	4	6		4	0	0	0
2	Төсөл, хөтөлбөр								
3	ОНТС	4		4					
4	ТТЗ	1	1			1	0	0	0
5	ТЕЗ								
6	ОНӨААН	3		3					
	НИЙТ	18	5	13		5	0	0	0